



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/36

Баян-Овоо сум

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 6 дугаар зүйл 6.1, 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8.1, 9.8.2, дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/59 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/150 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг сумын хэмжээнд 4 дүгээр багийн нийт үхрийг хамруулан 2026 оны 03 дугаар сарын 31-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл 21 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхийг "Түмэн сувд" хариуцлагатай хувьцаат компаний захирал (Ч.Амартүвшин), Малын эмч (М.Орхонтуул), "Эх цаг ХХК" хариуцлагатай хувьцаат компаний захирал (Ч.Нацаг), "Дэлгэрэх наран эрдэнэ" хариуцлагатай хувьцаат компаний захирал (Д.Жавзмаа), "Бидний оролцоо зөв" хариуцлагатай хувьцаат компаний захирал (Д.Баяртуяа) нарт үүрэг болгосугай

2. Дархлаажуулалтад хамруулах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, мал сүргээ бүрэн хамруулах, малчдад урьдчилан мэдэгдэж хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох газарт цаг хугацаанд нь мэдээ, мэдээллийг хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Шижирбаатар)-т даалгасугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР

Сумын Засаг даргын 20 21 оны 03 дүгээр
сарын 31-ний өдрийн 1/31 тоот
захирамжийн 1 хавсралт



ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

№	Сумын нэр	МЭҮНэгж	Дархлаажуулах малын тоо		Шаардлагатай вакцин	
			Үхэр	Нийт	Олгосон вакцин (тун)	вакцин (тун)
1	Баян-Овоо сум	Түмэн сувд ХХК	6506	6506	6500	13000
2	Баян-Овоо сум	Эх цаг ХХК	3643	3643	3650	7300
3	Баян-Овоо сум	Дэлгэрэх наран эрдэнэ ХХК	1561	1561	1550	3100
4	Баян-Овоо сум	Бидний оролцоо зөв ХХК	953	953	950	1900
Нийт			12663	12663	12650	25300